INTER AUDIT

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"Ард инвестмент групп" ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

УЛААНБААТАР ХОТ, 2026 ОН

"ИНТЕР АУДИТ" ХК

# АГУУЛГА

I. ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

II. ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

III. 2025 ОНЫ АУДИТ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
- АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
- АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
- АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

IV. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ИНТЕР АУДИТ ХХК

ОГНОО 2026.03.26 (1)

## "АРД ИНВЕСТМЕНТ ГРУПП" ХК-ИЙН МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| **КОМПАНИЙН НЭР:** | "Ард инвестмент групп" ХК |
| **РЕГИСТРИЙН ДУГААР:** | 2034611 |
| **КОМПАНИЙН УДИРДЛАГА:** | Ч. Ганхуяг /гүйцэтгэх захирал/ |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:** | Менежментийн зөвлөгөө өгөх |
| **КОМПАНИЙН ХАЯГ:** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Централ Тауэр, 17 давхар |
| **УТАС:** | 95957742 |

## АУДИТЫН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

INTER AUDIT

АУДИТОР, МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧИД
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Ч.МӨНХБАЯР

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 (2)

**Аудитын компанийн хаяг:**

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р хороолол, Самбуугийн гудамж, Эм Эн тауэр, 802 тоот

**Холбогдох:**

Утас: 99004839
Веб хуудас: www.interaudit.mn
Фэйсбүүк хуудас: Интер Аудит ХК / Inter Audit LLC
Мэйл хаяг: info@interaudit.mn

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

# 1

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 (3)

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

# "АРД ИНВЕСТМЕНТ ГРУПП" ХК-ИЙН УДИРДЛАГАД

## ДҮГНЭЛТ

Бид 2025 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон нэгдүгээр улирлын санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Ард инвестмент групп" ХК (цаашид "Компани" гэх)-ийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж буй "Ард инвестмент групп" ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31- ний өдрөөрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон нэгдүгээр улирлын орлогын дэлгэрэнгүй тайлан ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

## ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол Улсын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих шаардлагуудын дагуу тус байгууллагаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

## УДИРДЛАГА БОЛОН ЗАСАГЛАХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэгтэй бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага нь санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангаа гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу зогсолтгүй үйл ажиллагаа явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 (4)

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТАД ХҮЛЭЭХ АУДИТОРЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж, аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг.

Үүнд:

1. Залилан эсвэл алдааны улмаас тусдаа санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай ба зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

2. Байгууллагын дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоодхяналтын талаар ойлголт олж авдаг.

3. Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.

4. Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн байгууллагын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал байгууллага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

5. Тодруулгыг багтаагаад тусдаа санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж тусдаа санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид мөн засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагуудыг мөрдөж ажилласан болох мэдэгдлийг гаргаж өгсөн. Мөн бид хараат бус байдлаа хадгалахын тулд анхаарвал зохих харилцаа болон бусад асуудлын талаар засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгдсэн.

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан мэдээллүүдээс санхүүгийн тайлангийн аудитын хамгийн ач холбогдолтой гэж үзсэн асуудлыг аудитын гол асуудлаар сонгож аудиторын тайлангийн "Гол асуудал" хэсэгт оруулсан. Бид аудиторын тайланд тусгасан эдгээр асуудлууд нь хууль тогтоомж, дүрэм журмаар хориглосон гэж үзээгүй тул оруулсан болно.

Хүндэтгэсэн,

"ИНТЕР АУДИТ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.МӨНХБАЯР

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ
АУДИТ БАТАЛГААЖУУЛАЛТ
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ
ИНТЕР АУДИТ
ХХК
ТТА2532 РД 2712110
УЛААНБААТАР ХОТ

Тайлангийн огноо: 2026/03/26

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26

# ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# 2

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 7

# АУДИТ ХИЙСЭН ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| **А. ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ** | | |
| 1. Мөнгөн хөрөнгө | 2,269,478.13 | 531,206.25 |
| 2. Авлага | 2,586,562,500.00 | 2,848,694,787.95 |
| 3. Урьдчилж төлсөн тооцоо | 494,113,314.20 | 496,129,290.09 |
| 4. Бараа материал | - | - |
| 5. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **3,082,945,292.33** | **3,345,355,284.29** |
| 6. Үндсэн хөрөнгө | | |
| 7. Биет бус хөрөнгө | - | 21,937,980,000.00 |
| 8. Хойшлогдсон татварын хөрөнгө | - | - |
| 9. Урт хугацаат хөрөнгө оруулалт | 11,096,886,200.00 | 10,930,604,400.00 |
| 10. Бусад эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **11,096,886,200.00** | **32,868,584,400.00** |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 14,179,831,492.33 | 36,213,939,684.29 |
| 1. Богино хугацаат өглөг | 14,050,561,898.00 | 4,126,951,266.71 |
| 2. Урт хугацаат өглөг | 14,591,319.00 | 18,391,661,139.00 |
| **Өр төлбөрийн дүн** | **14,065,153,217.00** | **22,518,612,405.71** |
| 3. Өмч | 5,196,000.00 | 8,670,729,400.00 |
| 4. Өмчийн бусад хэсэг | 131,321,871.00 | 3,524,950,251.00 |
| 5. Нэмж төлөгдсөн капитал | - | 2,043,266,970.00 |
| 6. Дахин үнэлгээний нэмэгдэл | - | - |
| 7. Хуримтлагдсан ашиг, алдагдал | (21,839,595.67) | (543,619,342.42) |
| **Эзэмшигчийн өмчийн дүн** | **114,678,275.33** | **13,695,327,278.58** |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН | 14,179,831,492.33 | 36,213,939,684.29 |
| **Б. ОРЛОГЫН ТАЙЛАН** | | |
| 1. Цэвэр борлуулалт | 150,000,000.00 | - |
| 2. Борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг | - | - |
| **Нийт ашиг /алдагдал/** | **150,000,000.00** | **-** |
| 3. Ногдол ашгийн орлого | 169,830,708.87 | 254,700,000.00 |
| 4. Хүүний орлого | 30,708.87 | 23,410.91 |
| 5. Борлуулалт, маркетингийн зардал | - | - |
| 6. Ерөнхий ба удирдлагын зардал | 33,128,220.00 | 147,242,058.27 |
| 7. Санхүүгийн зардал | 285,863,013.66 | 603,287,671.16 |
| 8.Бусад зардал | 500,000.00 | 500,000.00 |
| 9. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | - | - |
| **Татварын өмнөх ашиг /алдагдал/** | **339,475.21** | **(496,306,318.52)** |
| Орлогын албан татварын зардал | 16,983,070.88 | 25,473,428.23 |
| НИЙТ ОРЛОГЫН ДҮН | (16,643,595.67) | (521,779,746.75) |
| **В. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН** | | |
| 1. Эхний үлдэгдэл | 15,805,800.00 | 114,678,275.33 |
| 2. Нэмэгдсэн | 115,516,071.00 | 14,102,428,750.00 |
| 3. Хорогдсон | 16,643,595.67 | (521,779,746.75) |
| 4. Эцсийн үлдэгдэл | 114,678,275.33 | 13,695,327,278.58 |
| **Г. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН** | | |
| 1. Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (21,138690.74) | (139,069,041.49) |
| 2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (2,300,074,331.13) | (27,465,345.39) |
| 3. Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 2,323,482,500.00 | 164,796,115.00 |
| 4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 2,269,478.13 | (1,738,271.88) |

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26
8

# 2025 ОНЫ АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# 3

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 (9)

# АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | ТОД | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|---|
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 4 | 2,269,478.13 | 531,206.25 |
| Дансны авлага | 5 | 2,586,562,500.00 | 2,848,694,787.95 |
| Хувьцааны авлага | - | - | - |
| Татвар, НДШ-ийн авлага | - | - | - |
| Бусад авлага | - | - | - |
| Бараа материал | - | - | - |
| Урьдчилж төлсөн зардал, тооцоо | 6 | 494,113,314.20 | 496,129,290.09 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө | - | - | - |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | | **3,082,945,292.33** | **3,345,355,284.29** |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ** | | | |
| Үндсэн хөрөнгө | - | - | |
| Биет бус хөрөнгө | 7 | - | 21,937,980,000.00 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 8 | 11,096,886,200.00 | 10,930,604,400.00 |
| **Хайгуул ба үнэлгээний хөрөнгө** | - | - | |
| **Хойшлогдсон татварын хөрөнгө** | - | - | |
| **Бусад эргэлтийн бус хөрөнгө** | - | - | |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | **11,096,886,200.00** | **32,868,584,400.00** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **14,179,831,492.33** | **36,213,939,684.29** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | | |
| Дансны өглөг | 9 | 11,545,677,269.57 | 1,617,371,855.73 |
| Хувьцааны өглөг | - | - | - |
| Цалингийн өглөг | - | 2,416,500.00 | 7,762,432.50 |
| Татварын өр | 10 | 861,631.14 | 660,331.19 |
| НДШ-ийн өглөг | - | 1,606,497.29 | 1,156,647.29 |
| Богино хугацаат зээл | 11 | 2,500,000,000.00 | 2,500,000,000.00 |
| Хүүний өглөг | - | - | |
| Урьдчилж орсон орлого | - | - | |
| Бусад богино хугацаат өр төлбөр | - | - | |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | | **14,050,561,898.00** | **4,126,951,266.71** |
| **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | | |
| Урт хугацаат зээл | - | - | |
| Хойшлогдсон татварын өр | 12 | 14,591,319.00 | 391,661,139.00 |
| Бусад урт хугацаат өр төлбөр | 13 | - | 18,000,000,000.00 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | | **14,591,319.00** | **18,391,661,139.00** |
| **ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН** | | **14,065,153,217.00** | **22,518,612,405.71** |
| **ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | | | |
| Өмч: - Хувийн | 14 | 5,196,000.00 | 8,670,729,400.00 |
| Нэмж төлөгдсөн капитал | - | - | 2,043,266,970.00 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 15 | 131,321,871.00 | 3,524,950,251.00 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | - | (21,839,595.67) | (543,619,342.42) |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | | **114,678,275.33** | **13,810,079,093.58** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН** | | **14,179,831,492.33** | **36,213,939,684.29** |

*Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.*

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26
10

# АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

*/Төгрөгөөр/*

| ҮЗҮҮЛЭЛТ | ТОД | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого /цэвэр/ | - | 150,000,000.00 | - |
| Борлуулалтын өртөг | - | - | - |
| **НИЙТ АШИГ /АЛДАГДАЛ/** | | 150,000,000.00 | - |
| Түрээсийн орлого | - | - | - |
| Хүүгийн орлого | 16 | 30,708.87 | 23,410.91 |
| Ногдол ашгийн орлого | 17 | 169,800,000.00 | 254,700,000.00 |
| Эрхийн шимтгэлийн орлого | - | - | - |
| Бусад орлого | - | - | - |
| Борлуулалт, маркетингийн зардал | - | - | - |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 18 | 33,128,220.00 | 147,242,058.27 |
| Санхүүгийн зардал | 19 | 285,863,013.66 | 603,287,671.16 |
| Бусад зардал | - | 500,000.00 | 500,000.00 |
| Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз /гарз/ | - | - | - |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/ | - | - | - |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/ | - | - | - |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/ | - | - | - |
| Бусад ашиг /алдагдал/ | - | - | - |
| **Татварын өмнөх ашиг /алдагдал/** | | 339,475.21 | **(496,306,318.52)** |
| Орлогын татварын зардал | 20 | 16,938,070.88 | 25,473,428.23 |
| **ТАТВАРЫН ДАРААХ АШИГ /АЛДАГДАЛ/** | | (16,643,595.67) | (521,779,746.75) |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/ | - | - | - |
| **Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/** | | (16,643,595.67) | **(521,779,746.75)** |
| Үүнээс: | - | - | - |
| Толгой компанийн эзэмшигчдэд ногдох | - | - | - |
| Хяналтын эрхгүй хувь оролцоог эзэмшигчдэд ногдох | - | - | - |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - |
| Бусад олз /гарз/ | - | - | - |
| **НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО** | | (16,643,595.67) | (521,779,746.75) |
| **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/** | | - | - |

*Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.*

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26
11

# АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ | НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ | ХАЛААСНЫ ХУВЬЦАА | ЭЗДИЙН ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ | ХУРИМТЛАГДСАН АШИГ (АЛДАГДАЛ) | НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|---|---|
| **2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **5,196,000.00** | **-** | **-** | **15,805,800.00** | **(5,196,000.00)** | **15,805,800.00** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - | - | - |
| **ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ** | **5,196,000.00** | **-** | **-** | **15,805,800.00** | **(5,196,000.00)** | **15,805,800.00** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | (16,643,595.67) | **(16,643,595.67)** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | 115,516,071.00 | - | **115,516,071.00** |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - | - | - |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - | - |
| **2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **5,196,000.00** | **-** | **-** | **131,321,871.00** | **(21,839,595.67)** | **114,678,275.33** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - | - | - |
| **ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ** | **5,196,000.00** | **-** | **-** | **131,321,871.00** | **(21,839,595.67)** | **114,678,275.33** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | (521,779,746.75) | **(521,779,746.75)** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | 3,393,628,380.00 | - | **3,393,628,380.00** |
| Өмчид гарсан өөрчлөлт | 8,665,533,400.00 | 2,043,266,970.00 | - | - | - | **10,708,800,370.00** |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - | - |
| **2025 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ҮЛДЭГДЭЛ** | **8,670,729,400.00** | **2,043,266,970.00** | **-** | **3,524,950,251.00** | **(543,619,342.42)** | **13,695,327,278.58** |

*Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.*

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 12

# АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО** | **-** | **47,028,600.00** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | - | - |
| Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | - | - |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | - | - |
| Буцаан авсан албан татвар | - | - |
| Татаас, санхүүжилтийн орлого | - | - |
| Бусад мөнгөн орлого | - | 47,028,600.00 |
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА** | **21,138,690.74** | **186,097,641.49** |
| Ажилчдад төлсөн | 5,901,557.29 | 600,000.00 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 2,491,485.71 | 2,000,000.00 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | - | - |
| Ашиглалтын зардалд төлсөн | - | - |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | - | - |
| Хүүний төлбөрт төлсөн | - | - |
| Татварын байгууллагад төлсөн | 742,853.74 | 863,259.09 |
| Даатгалын төлбөрт төлсөн | - | - |
| Бусад мөнгөн зарлага | 12,002,794.00 | 182,634,382.40 |
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(21,138,690.74)** | **(139,069,041.49)** |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО** | **30,708.87** | **21,282.65** |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| Биет бус хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | - | - |
| Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | - | - |
| Хүлээн авсан хүүний орлого | 30,708.87 | 21,282.65 |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА** | **2,300,105,040.00** | **27,486,628.04** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | - | 22,264,743.00 |
| Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 2,300,105,040.00 | 5,221,885.04 |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(2,300,074,331.13)** | **(27,465,345.39)** |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО** | **2,324,982,500.00** | **164,796,115.00** |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 2,324,982,500.00 | 164,796,115.00 |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | - |
| Бусад мөнгөн орлого | - | - |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА** | **1,500,000.00** | **-** |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | 1,500,000.00 | - |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | - | - |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **2,323,482,500.00** | **164,796,115.00** |
| Валютын ханшийн зөрүү | - | |
| **БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **2,269,478.13** | **(1,738,271.88)** |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 2,269,478.13 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,269,478.13 | 531,206.25 |

*Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.*

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 13

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

# 4



ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 14

## 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

"Ард инвестмент групп" Хувьцаат Компани (цаашид компани гэх) нь 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан. Тус компани нь менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг явуулж байна. 2026 оны 01 сарын 29-нд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр компанийн оноосон нэрийг Ард Инвестмент Групп болгож өөрчилсөн.

**Ард инвестмент групп ХК-ийн хувьцаа эзэмшигчдийг топ 10 болон бусад байдлаар доор харуулав:**

| № | Хувьцаа эзэмшигчдийн нэр | Хувьцааны тоо /ширхэг/ | Нэгжийн үнэ | Дүн /төгрөг/ | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ардын тэтгэврийн данс ХХК | 12948506 | 100.00 | 1,294,850,600.00 | 14.9% |
| 2 | Ард БИТ ХХК | 11545460 | 100.00 | 1,154,546,000.00 | 13.3% |
| 3 | Raschle Bruno Eduard | 9791940 | 100.00 | 979,194,000.00 | 11.3% |
| 4 | Авир Сүхдорж | 9026440 | 100.00 | 902,644,000.00 | 10.4% |
| 5 | Чулуун Ганхуяг | 7662709 | 100.00 | 766,270,900.00 | 8.8% |
| 6 | Галням Уянга | 6453900 | 100.00 | 645,390,000.00 | 7.4% |
| 7 | Эйч Ви Эл Эл ХХК | 6452020 | 100.00 | 645,202,000.00 | 7.4% |
| 8 | Ард Венчурс ХХК | 5334300 | 100.00 | 533,430,000.00 | 6.2% |
| 9 | Ард лизинг ХХК | 4848420 | 100.00 | 484,842,000.00 | 5.6% |
| 10 | Ард кредит ББСБ ХХК | 1838860 | 100.00 | 183,886,000.00 | 2.1% |
| 11 | Бусад | 10804739 | 100.00 | 1,080,473,900.00 | 12.5% |

## 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН СУУРЬ ЗАРЧИМ

### НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДЭС:

Компанийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-д нийцүүлэн бэлтгэсэн. Санхүүгийн тайлангууд нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тайлбар тодруулгаас бүрдэж байна.

### ҮНЭЛГЭЭ:

Санхүүгийн тайланд хөрөнгө, өр төлбөр, өмчийг түүхэн өртгийн зарчмаар хэмжиж бүртгэсэн.

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН ВАЛЮТ:

Компанийн ажил гүйлгээний хэмжих нэгж нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөг (MNT) юм. Санхүүгийн тайлангийн тодруулгад тоон үзүүлэлтүүдийг төгрөгөөр бэлтгэсэн.

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 15

### НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СУУРЬ:

Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт зарчимд үндэслэн бэлтгэдэг.

### САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ТӨСӨӨЛӨЛ:

Мөрдөж байгаа хууль эрх зүйн болон бизнесийн орчинд компанийн цаашдын үйл ажиллагаанд нөлөөлөхүйц өөрчлөлт орох хандлага ба төсөөлөлгүй байна. Компани ирээдүйд үндсэн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулна гэсэн итгэл үнэмшилд тулгуурлан санхүүгийн тайлангаа бэлтгэсэн.

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

### МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалтаар банкин дахь харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгүүдээс бүрдэнэ. Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлнэ.

### ГАДААД ВАЛЮТЫН БҮРТГЭЛ

Санхүүгийн тайланг Монгол төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд компани үйл ажиллагаагаа явуулдаг албан ёсны мөнгөн тэмдэгт нь Монгол улсын мөнгөн тэмдэгт - Монгол төгрөг (MNT) юм. Гадаад улс орны валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөр, гүйлгээг тайлан гаргасан өдрийн Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлж санхүүгийн тайланд тусгана.

Хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг бөгөөд нэрлэсэн үнийг тухайн өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэлд тусгана.

### САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Компани нь хувьцаа, авлагын болон өрийн бичиг зэрэг санхүүгийн хэрэглүүрийг гаргаж, нийтэд арилжаалаагүй. Компани санхүүгийн хэрэглүүрийн хэлцлийн оролцогч нэг тал болсон тохиолдолд санхүүгийн хэрэглүүрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

### ДАНСНЫ БА БУСАД АВЛАГА

Авлагыг худалдан авагч, харилцагчдаас нэхэмжилсэн дүнгээр хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Компанийн нягтлан бодох бүртгэлийн зохион байгуулалт нийцүүлэн авлагыг төрөл зүйлээр ангилан санхүүгийн тайланд тусгана.

### БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг олж бэлтгэсэн өртгөөр үнэлэн, ижил төрлийн хөрөнгүүдийг эхэлж авснаа эхэлж зарлагадах аргаар бүртгэнэ. Аж ахуйн ба хангамжийн материал, бараа, бүтээгдэхүүнийг төрөл зүйлээр ангилан санхүүгийн тайланд бүлэглэн үзүүлнэ.

### УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО

Гадаад болон дотоодын зах зээлээс түүхий эд материал худалдан авахаар төлсөн төлбөр, бусад бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгчид төлсөн урьдчилгааг нэрлэсэн үнээр нь хэмжиж, урьдчилж төлсөн зардал, урьдчилж төлсөн тооцооны хэсэгт нэрийн данс нээж бүртгэдэг.

### ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн ба санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, хүлээн зөвшөөрөх нөхцөлийн дагуу, анхны өртгөөр хэмжиж үнэлэн зохих ангиллын дансанд бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авалтын өртөг, хөрөнгийг ашиглалтын хэвийн нөхцөлд оруулахад шууд хамаарах зардлаас бүрдэнэ. Анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, үнэ цэний бууралтын алдагдлыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд тусгана.

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 16

## УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Урт хугацаат хөрөнгө оруулалтыг мөнгөөр хийсэн бол нэрлэсэн үнээр, мөнгөнөөс бусад хөрөнгөөр хийсэн тохиолдолд тэдгээр хөрөнгийн зах зээлийн бодит үнэ цэнээр хөрөнгө оруулалтын анхны өртгийг тодорхойлж бүртгэнэ.

## ӨР ТӨЛБӨР

Компанийн нийт өр нь богино болон урт хугацаат өр төлбөрүүдээс бүрдэнэ. Өр төлбөрүүдийг байгууллага, хувь хүмүүст өгөх өглөг, банкны богино хугацаат зээл, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг болон бусад богино хугацаат өглөг, банкны урт хугацаат зээл гэж ангилсан.

Өр төлбөрийг нэрлэсэн үнээр бүртгэж тайлагнана. Тайлант онд компаниас төлөх өр төлбөрүүдэд хөнгөлөлт ба хасагдуулаг тооцогдоогүй.

## ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Тайлангийн өмнөх үеийн ба тайлант оны хуримтлагдсан ашгийг тооцоологдсон дүнгээр хүлээн зөвшөөрч өөрийн хөрөнгийн бүлэгт тусган үзүүлнэ.

## БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Компанийн орлогын ихэнх хувийг худалдан авагч буюу захиалагч талтай байгуулсан богино болон урт хугацааны гэрээний орлого эзэлдэг. Компани нь гэрээний гүйцэтгэлийн үүргээ биелүүлснээр орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Гэрээний үүрэг дуусаагүй, гүйцэтгэх явцад захиалагч талаас төлөгдөх урьдчилгаа төлбөрүүдийг урьдчилж олсон орлого дансанд бүртгэдэг.

Орлогыг аливаа хөнгөлөлт, үнэ цэний бууралт, борлуулалттай холбоотой бусад төлбөрийг хассаны дараа хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж үнэлнэ.

## БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

Компани нь гэрээний үүргийн биелэлтийн гүйцэтгэлтэй уялдуулан өртгийг хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Гэрээний үүрэг дуусаагүй, гүйцэтгэх явцад гэрээт ажилтай холбоотой гарсан шууд зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримлуулан бүртгэдэг.

## ЗАРДАЛ

Компанийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий ба удирдлага, борлуулалт болон маркетингийн зардлуудыг аккруэл сууриар хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Зардлуудыг нягтлан бодох бүртгэлийн ба санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох заавар журмын аргачлалд нийцүүлэн төрлөөр ангилж орлогын тайланд үзүүлнэ.

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 17

## 4. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| Банкин дахь бэлэн мөнгө | 2,269,478.13 | 531,206.25 |
| ДҮН | 2,269,478.13 | 531,206.25 |

**Тайлбар:** Компани нь Худалдаа Хөгжлийн Банкинд харилцах данс эзэмшдэг бөгөөд тайлангийн өдрөөрх дансны үлдэгдлийг дээр харуулав.

## 5. ДАНСНЫ АВЛАГА

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| Ард Санхүүгийн Нэгдэл ХК | 2,486,562,500.00 | 2,176,658,903.00 |
| Гэр Интерьер Дизайн ХХК | - | 309,903,597.00 |
| Тэнгэр Системс ХХК | - | 229,230,000.00 |
| Бусад авлага | 100,000,000.00 | 10,857,987.95 |
| Хувьцааны авлага | - | 122,044,300.00 |
| ДҮН | 2,586,562,500.00 | 2,848,694,787.95 |

## 6. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| Ард Санхүүгийн Нэгдэл ХК | 300,060,000.00 | 300,060,000.00 |
| Ард Секюритиз ҮЦК | 177,238,420.20 | 177,238,420.20 |
| Бусад урьдчилж төлсөн тооцоо | 16,814,894 | 18,830,869.89 |
| ДҮН | 494,113,314.20 | 496,129,290.09 |

## 8. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| ARDT | - | 7,599,980,000.00 |
| ARDX | - | 14,338,000,000.00 |
| ДҮН | - | 21,937,980,000.00 |

**Тайлбар:** Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тушаалаар 200.0 мянган ширхэг ARDT, 2,000.0 мянган ширхэг ARDX худалдаж авсан байна.

## 7. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 11,096,886,200.00 | 10,930,604,400.00 |
| ДҮН | 11,096,886,200.00 | 10,930,604,400.00 |

**Тайлбар:** Компани нь 2023 онд хувьцаа худалдан авсан бөгөөд тайлангийн өдрөөрх хувьцааны бодит үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь дараах байдалтай байна.

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 18

## 9. ДАНСНЫ ӨГЛӨГ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| Ард Санхүүгийн Нэгдэл ХК | 612,333,269.57 | 1,482,580,040.73 |
| Ард Секюритиз ҮЦК | - | 109,751,815.00 |
| Ард БИТ ХХК | - | 3,000,000.00 |
| Крипто Үндэстэн ХК | - | 1,000,000.00 |
| Кроонос ХХК | - | 21,000,000.00 |
| Хувь хүнээс авах авлага | 40,000.00 | 40,000.00 |
| Хувьцааны өглөг | 10,933,304,000.00 | - |
| **ДҮН** | **11,545,677,269.57** | **1,617,371,855.73** |

**Тайлбар:** Компани нь тайлант онд нэмж гаргасан хувьцааг бүртгэн хувьцааны өглөгийг хаасан байна.

## 10. ТАТВАР, НДШ-ИЙН ӨГЛӨГ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| ХХОАТ-ын өр | 861,631.14 | 661,159.48 |
| ОАТ-ын өр | - | (828.29) |
| **ДҮН** | **861,631.14** | **660,331.19** |

## 11. БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| Богино хугацаат зээл | 2,500,000,000.00 | 2,500,000,000.00 |
| **ДҮН** | **2,500,000,000.00** | **2,500,000,000.00** |

**Тайлбар:** Компани нь өмнөх онд Ард Актив ХКХ-с 24 сарын хугацаатай, жилийн 24%-ийн хүүтэй зээл авсан бөгөөд үндсэн зээлийг хугацааны эцэст төлөхөөр байна.

## 13. ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ӨГЛӨГ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| ARDT | 14,903,520.00 | (40,002,000.00) |
| ARDX | - | 433,800,000.00 |
| Крипто Үндэстэн ХК | - | (3,279,360.00) |
| Өндөрхаан ХК | (312,201.00) | 1,142,499.00 |
| **ДҮН** | **14,591,319.00** | **391,661,139.00** |

## 14. БУСАД УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| Ардкредит ББСБ | - | 5,000,000,000.00 |
| Бусад өр төлбөр | - | 13,000,000,000.00 |
| **ДҮН** | **-** | **18,000,000,000.00** |

**Тайлбар:** Компани нь биет бус хөрөнгийг зээлээр худалдан авсан ба бусад урт хугацаат өр төлбөрт бүртгэн толилуулсан.

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 19

## 15. ӨМЧ

| ҮЗҮҮЛЭЛТ | ЭРГЭЛТЭД БАЙГАА БҮРЭН ТӨЛӨГДСӨН ЭНГИЙН ХУВЬЦАА | | ДАВУУ ЭРХТЭЙ ХУВЬЦАА | | ӨМЧИЙН ДҮН (ТӨГРӨГӨӨР) |
|---|---|---|---|---|---|
| | ТОО ШИРХЭГ | ДҮН (ТӨГРӨГӨӨР) | ТОО ШИРХЭГ | ДҮН (ТӨГРӨГӨӨР) | |
| Эхний үлдэгдэл | 51,956 | 5,196,000.00 | - | - | 5,196,000.00 |
| Нэмэгдсэн | 8,665,533.4 | 8,665,533,400.00 | - | - | 8,665,533,400.00 |
| Хасагдсан | - | - | - | - | - |
| ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ | 8,670,729.4 | 8,670,729,400.00 | - | - | 8,670,729,400.00 |

**Тайлбар:** Компанийн дүрмийн сан нь нэг бүр нь 100.00 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 8,670,729.4 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна. Тайлант оны хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр нэмж хувьцаа гаргасан байна.

## 16. ЭЗДИЙН ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| Бодит үнэ цэнийн тохируулгын нөөц | 15,805,800.00 | 3,524,950,251.00 |
| ДҮН | 15,805,800.00 | 3,524,950,251.00 |

## 17. ХҮҮНИЙ ОРЛОГО

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| Хүүний орлого | 30,708.87 | 23,410.91 |
| ДҮН | 30,708.87 | 23,410.91 |

## 17. НОГДОЛ АШГИЙН ОРЛОГО

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| ГрэйпСити Монгол ХХК | 169,800,000.00 | 254,700,000.00 |
| ДҮН | 169,800,000.00 | 254,700,000.00 |

## 18. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| Ажилчдын цалингийн зардал | 18,279,929.00 | 7,381,666.67 |
| Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал | 2,092,191.00 | 775,075.00 |
| Бичиг хэргийн зардал | - | 179,485.00 |
| Шуудан холбооны зардал | 162,800.00 | 314,615.00 |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | 12,578,500.00 | 16,837,173.60 |
| Түрээсийн зардал | - | 100,000,000.00 |
| Хүлээн авалтын зардал | - | 21,500,000.00 |
| Банкны шитгэлийн зардал | 14,800.00 | 254,043.00 |
| ДҮН | 33,128,220.00 | 147,242,058.27 |

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 20

## 19. САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| Ард Актив ХЗХ | 285,863,013.66 | 603,287,671.16 |
| ДҮН | 285,863,013.66 | 603,287,671.16 |

**Тайлбар:** Богино хугацаат зээлийн хүүгийн эргэн төлөлтийг санхүүгийн зардал болгон бүртгэсэн.

## 20. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| Орлогын татварын зардал | 3,070.88 | 25,473,428.23 |
| ДҮН | 3,070.88 | 25,473,428.23 |

## 21. ХОЛБООТОЙ ТАЛААС АВАХ АВЛАГА

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| Ард Санхүүгийн Нэгдэл ХК | 2,486,562,500.00 | 2,176,658,903.00 |
| Гэр интерьер дизайн ХХК | - | 309,903,597.00 |
| Өндөрхаан ХК | 100,000,000.00 | - |
| ДҮН | 2,586,562,500.00 | 2,486,562,500.00 |

## 22. ХОЛБООТОЙ ТАЛД ӨГӨХ ӨГЛӨГ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|
| Ард Санхүүгийн Нэгдэл ХК | 612,333,269.57 | 1,482,580,040.73 |
| ДҮН | 612,333,269.57 | 1,482,580,040.73 |

## 23. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА БА БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛС

Бусад хууль тогтоомж, зохицуулагч байгууллагуудаас гаргасан дүрэм, журамтай холбоотой ямар нэгэн үүрэг хариуцлага үүсгэж болохуйц үйл явдал үүсээгүй байна.

## 24. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Энэхүү тайланг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр бэлтгэсэн. Тасалбар болгосноос хойш компани нь 2026 оны 01 сарын 29-нд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр компанийн оноосон нэр Ард Инвестмент Групп болж өөрчлөгдсөн байна.

ИНТЕР АУДИТ ХХК
ОГНОО 2026.03.26 21

"ИНТЕР АУДИТ" ХК

**Аудитын компанийн хаяг:**

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р хороолол, Самбуугийн гудамж, Эм Эн тауэр, 802 тоот

**Холбогдох:**

Утас: 99004839
Веб хуудас: www.interaudit.mn
Фэйсбүүк хуудас: Интер Аудит ХК / Inter Audit LLC
Мэйл хаяг: info@interaudit.mn